


**“АБТС ББСБ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН 2023 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Тайлагнах хугацаа	2023.01.01-2023.12.31
Тайлан гаргасан	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Чанзавцог

Тайланг хянаж баталсан:

ТУЗ-ийн дарга Т. Тамир 

№	Компанийн засаглалын бодлого, үйл ажиллагаа
1	Компанийн засаглал шинэтгэлийн хүрээнд ТУЗ болон удирдлагын багт шинэтгэлийн талаар мэдээлэл хүргүүлэх, эдгээр шинэтгэлүүдийг компани дээр хэрэгжүүлэх арга боломжийн талаар тухай бүр зөвлөмж өгч ажиллав. Ингэснээр ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журам, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороог байгуулах судалгааны ажлыг хийж журам боловсруулах ажилд зөвлөгөө өгч ажиллав. Эрсдэлийн удирдлагын бодлого, Комплайнсын хяналтын заавар, Дотоод хяналтын бодлого, Оролцогч талуудтай хамтран ажиллах бодлого зэрэг бодлогын төслүүдийг 2024 оноос хэрэгжүүлж ажиллах бэлтгэл ажилд ТУЗ-ийн гишүүдээс санал авч ажилласан.
2	ТУЗ-ийн гишүүдэд олгох сургалтын 2023 оны төлөвлөгөөг боловсруулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

3	ХЭ-ын 2023 оны хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлыг хуулийн дагуу зохион байгуулж ХЭХ-аар 5 асуудал хэлэлцүүлж 2 тогтоол батлагдсан.
---	---

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал, Хороодын хурал

4	“АБТС ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн хулыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж хэлэлцэх асуудлуудын хүрээнд холбогдох мэдээллийг бэлтгэн нийт 9 удаа хуралдаж хэлэлцсэн асуудлуутай холбоотой тогтоол шийдвэр гарсан. Мөн ТУЗ-ийн дэргэд шинээр байгуулах 3 хорооны үйл ажиллагааг ТУЗ-ийн хуралд танилцуулж компанийн засаглалыг сайжруулах бусад холбогдох журам, бодлогын баримт бичгийг боловсруулах талаар санал авч ажиллав.
---	--

Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт, тайлан

5	
---	--

	Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны 145 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-д заасны дагуу компанийн засаглалыг сайжруулах компанийн үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой сайн засаглалтай байлгах зорилгоор холбогдох хороо байгуулах түүнийг дагасан журам, бодлогын баримт бичгийг боловсруулах 2024 оноос мөрдөн ажиллах бэлтгэл ажлыг ханган журам, бодлогын төсөл зэргийг боловсруулах ажлыг ТУЗ-д танилцуулах, зөвлөх, хянах зэрэг ажлын хэрэгжүүлэн ажиллаж байна.
6	Монгол улсын хууль тогтоомжид заасан тайлан тооцоог боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.
ТУЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилт	
7	ТУЗ болон хороодоос гарсан тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавин ажилласан.
Компанийн бичиг баримтын бүрдэл, бүртгэл, хадгалалт	
8	ТУЗ-өөс баталсан тогтоол, хурлын баримтуудыг хөтлөн шаардлагатай асуудлаар дүн шинжилгээ дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулж ажилласан.